



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2022.12.28 № 01/2467
танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР,
ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн болон холбогдох бусад шийдвэрүүдийн 2023оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар:

1.1. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 8.5 хувь” гэж заасны дагуу 2023 онд ажил олгогч нийгмийн даатгалын таван төрөлд үйл ажиллагааны чиглэлээс хамааран нийтдээ хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоосоо 12.5, 13.5, 14.5 хувь, албан журмын даатгуулагч хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо 11.5 хувь, сайн дурын даатгуулагч 13.5 хувиар, хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа жирэмсний, амаржсаны тэтгэмж авсан сайн дураар даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төгрөг)-ний 12.5 хувьд ногдох хэсгийн 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг өөрөө хариуцан төлсөн тохиолдолд үлдсэн 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг тэтгэмжийн даатгалын сангаас, харин бусад сайн дураар даатгуулагч эх 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг өөрөө хариуцан төлсөн тохиолдолд үлдсэн 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг улсын төсвөөс тус тус тооцон шимтгэл төлнө.

1.2. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард таван зуун тавин мянган (550 000) төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Иймд сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтийг доор дурдсанаар мөрдөнө. Үүнд:

1522072400

1.2.1. Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын доод хэмжээг таван зуун тавин мянган (550 000) төгрөг, дээд хэмжээг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны "Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоох тухай" 251 дүгээр тогтоолыг баримтлан таван сая таван зуун мянган (5 500 000) төгрөгөөр тооцно.

1.2.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцохоор хуульд заасан хугацаанд төр, аж ахуйн нэгж, байгууллагаас сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам"-ын дагуу төлөх шимтгэлийн хэмжээг тэтгэврийн даатгалд 8.5 хувь, тэтгэмжийн даатгалд 1.0 хувь, нийт 9.5 хувиар, жирэмсний болон амаржсаны амралттай болон 1 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжавсан хугацаанд тэтгэврийн даатгалд 8.5 хувь, тэтгэмжийн даатгалд 0.8 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 0.8-2.8 хувь, ажилгүйдлийн даатгалд 0.2 хувь, эрүүл мэндийн даатгалд 2.0 хувь, нийт 12.5-14.5 хувь байхаар тус тус тооцож төлүүлнэ.

1.2.3. Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төгрөг)-нээс 8.5 хувиар тооцсон дүнгээр буюу сард 46 750 төгрөгөөр тооцон төлж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны 131 дүгээр тушаалаар баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, төлбөр хийх, тайлагнах журам"-ын дагуу тооцоо хийнэ.

1.2.4. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам"-ын 2 дахь хэсгийн "ж"-д заасан цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалд 1.0 хувь, нийтдээ 12.5 хувиар буюу 68 750 төгрөгөөр тооцно.

1.2.5. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу цэргийн алба хаагчийн 1995 оноос хойш алба хаасан хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлийг нийт хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгээс тэтгэврийн даатгалд 8.5 хувь, тэтгэмжийн даатгалд 1.0 хувь, нийтдээ 9.5 хувиар, харин цэргийн алба хаагчийн өсгөн эсхүл шилжүүлэн тооцсон болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн жинхэнэ албыг байлдагч, түрүүчээр хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан хугацааны шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

(550 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалд 8.5 хувь, тэтгэмжийн даатгалд 1.0 хувь, нийтдээ 9.5 хувиар тус тус тооцон төлүүлнэ.

1.2.6. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээгээр болон түүнээс өндөр цалин хөлс авсан албан журмын даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн дээд хэмжээ 632500 төгрөг (5500 000 төгрөг*11.5%), сайн дурын даатгуулагчийнх 742500 төгрөг (5500 000 төгрөг*13.5%) байна.

1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн хүсэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/191дүгээр тушаалаар даатгуулагчийн төрлийн “70”, “71” шинэ кодыг баталсан.

1.3.1. Энэхүү тушаалаар баталсны дагуу нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр, улсын төсвөөс цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр болон 16 насанд хүрсэн одой хүн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэйн улмаас нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон боловч хөдөлмөр эрхэлж байгаа даатгуулагчийн ажил олгогчоос олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд даатгуулагчийн төрлийн “70” кодоор бүртгэж, ажил олгогчийн төлбөл зохих тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 10.3-12.3 хувь, даатгуулагчийн төлбөл зохих тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 9.3 хувь, нийт 19.6-21.6 хувиар тооцон төлүүлнэ.

Иймд ажил олгогчтой дээр дурдсан гэрээ байгуулж, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого авсан хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар алдан тахир дутуугийн, цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны, нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон ажилтныг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд даатгуулагчийн төрлийн “70” кодоор тайлагнана.

Энэ тохиолдолд өмнө нь тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан буюу даатгуулагчийн төрлийн “22” кодоор тайлагнаж байсан тахир дутуугийн, цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны, нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар алдсан иргэн энгийнээр ажиллаж байгаа тохиолдолд даатгуулагчийн төрлийн “70” кодоор тайлагнана. Харин цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосны дараа цэрэг, цагдаагийн байгууллагад цэргийн цолтойгоор алба хааж байгаа ажилтныг даатгуулагчийн төрлийн “69” кодоор тайлагнана.

Өндөр насны, цэргийн алба хаасны, эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насанд хүрсэн нийгмийн халамжийн тэтгэвэр авагч нь аж ахуйн нэгж, байгууллагад энгийнээр ажиллаж байгаа бол даатгуулагчийн төрлийн “22” кодоор, тэтгэвэр тогтоолгосны дараа цэрэг, цагдаагийн байгууллагад цэргийн цолтойгоор алба хааж байгаа ажилтныг даатгуулагчийн төрлийн “69” кодоор тус тус хэвээр нь тайлагнана.

1.3.2. Төрийн тусгай албанд цэрэг /цагдаа/-ийн цолтойгоор алба хааж байгаа ажилтны тухайн байгууллагын захиалгаар төрийн зардлаар суралцсан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд даатгуулагчийн төрлийн “71” кодоор бүртгэж, тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2.0 хувиар төлүүлнэ.

Энэ тохиолдолд цэргийн алба хаагчийн тухайн байгууллагаасаа чөлөөлөгдсөн тушаал гарч цэрэг /хууль сахиулахын/-ийн сургуульд сонсогчоор суралцсан хугацааг даатгуулагчийн төрлийн “08” кодоор, харин байгууллагынхаа захиалгаар суралцаж байгаа цэргийн алба хаагчид уг хугацаанд тухайн байгууллагаас хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгоогүй бол даатгуулагчийн төрлийн “71” кодоор тайлагнана.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн талаар:

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр 2023 онд нийгмийн даатгалын шимтгэлийг 21 жил 6 сар ба түүнээс дээш хугацаанд төлсөн эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

2.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэн 2023 онд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (21 жил 6 сар)-г хангаагүй буюу 20-21 жил 5 сар шимтгэл төлсөн тохиолдолд төрсөн ондоо харгалзах насанд хүрч өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. Түүнчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-19 жил 11 сар төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох даатгуулагч мөн төрсөн ондоо харгалзах тэтгэврийн насанд хүрсэн байна.

2.3. Өндөр насны тэтгэврийн нөхцөл (21 жил 3 сар хүртэл төлсөн, төрсөн ондоо харгалзах нас)-ийг 2022 онд хангасан боловч тэтгэвэр тогтоолгох өргөдлөө 2023 онд гаргасан даатгуулагчид 2022 онд хангасан нөхцөлөөр нь тэтгэвэр тогтооно.

2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/185, “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай” А/186 дугаар тушаалуудыг тус тус хүргүүлж байна.

Эдгээр тушаалаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Иймд дээрх тушаалуудын хэрэгжилтийг зохион байгуулан, уг тушаалд заасан ажил, мэргэжлээр ажилласан даатгуулагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд түүнд өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоож, олгоно.

2.5. Засгийн газрын 2017 оны “Нийгмийн даатгалын шимтгэлтөлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоох тухай” 251 дүгээр тогтоол болон Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор баталсны дагуу нийгмийн

даатгалын сангаас тогтоож, олгох бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж болон цэргийн тэтгэврийг тооцоход баримтлах сарын хөдөлмөрийн хөлс орлогын дээд хэмжээ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн таван сая таван зуун мянга (5 500 000) төгрөг байх бөгөөд тэтгэвэр, тэтгэмж тогтоох дундаж цалинг тодорхойлохдоо энэхүү дээд хэмжээг баримтална.

2.6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тогтоох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны сарын бүрэн тэтгэврийн доод хэмжээ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс таван зуун тавин мянган (550 000) төгрөг байна. Энэ зохицуулалт Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэрт мөн адил хамаарна.

Харин Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна” гэж заасан тул Засгийн газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолоор баталсны дагуу цэргийн тэжээгчээ алдсаны 3 буюу түүнээс дээш хөдөлмөрийн чадваргүй гишүүнд олгогдох тэтгэврийн доод хэмжээ 500 000 төгрөг хэвээр байна.

3. Нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн талаар:

3.1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан даатгуулагчийн оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөг (2 000 000)-өөр шинэчлэн, оршуулгын тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөг (3 500 000)-өөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн болно.

Иймд нийгмийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмж олгоход Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/72 дугаар тушаалаар баталсан “Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг баримтална. Харин амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж олгохдоо энэхүү журмын 3.12-т заасан баримт бичгээс гадна Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас Эрүүл мэндийн сайдын баталсан маягтын дагуу олгосон “Даатгуулагчийг донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт”-ыг үндэслэнэ.

Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж (3 500 000 төгрөг) олгосон тохиолдолд 2 000 000 төгрөгийн оршуулгын тэтгэмжийг давхардуулан олгохгүй.

Энэ тохиолдолд 2022 онд нас барсан даатгуулагчийн ар гэрээс оршуулгын тэтгэмж авах хүсэлтээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан хугацаанд багтааж гаргасан нь 2023 он дамжсан бол энэ зөвлөмжид заасан хэмжээ (2 000 000 төгрөг)-гээр оршуулгын тэтгэмжийг олгоно. Харин шинээр тогтоосон амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш уг тэтгэмжийг авах эрх үүссэн тохиолдолд олгоно.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн талаар:

4.1.Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувь ($550\ 000\ \text{төгрөг} * 75\% = 412\ 500\ \text{төгрөг}$ / $21.2\ \text{хоног} * 76\ \text{хоног} = 1\ 478\ 773\ \text{төгрөг}$)-аас багагүй байна.

Энэ тохиолдолд даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ гаргасан нь 2023 он дамжсан бол энэхүү зөвлөмжид заасан хэмжээгээр ажилгүйдлийн тэтгэмжийг олгоно.

5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

5.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар 2023 онд иргэдийн төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг дараах хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ:

5.1.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар;

5.1.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.12-т заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төг)-ний 1 хувиар буюу сарын 5500 төгрөг, жилийн 66000 төгрөгөөр тооцож төлүүлэх;

5.1.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), 0-18 насны хүүхэд, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төг)-ний 2 хувиар буюу сарын 11 000 төгрөг, жилийн 132000 төгрөгөөр тооцож төлүүлэх.


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/185, “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай” А/186 дугаар тушаал, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн

тогтоох тухай” 10 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/191 дүгээр тушаалын хуулбарыг тус тус хавсаргав.

Хавсралт 10 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  А.АРИУНБОЛД





ХОДОЛМОР, НИЙГМИЙН ТУНШЛЭЛИЙН
ГУРВАН ТАЛТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 10

Утасны н. н. 97
Утас 7720-005

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард 550000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. 2024 онд мөрдөгдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан шинэчлэн тогтоохоор шийдвэрлэсүгэй.

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД



А.АРИУНЗАЯА

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ, ЭЗДИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын Ү байр, Б Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15169
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@tojha.gov.mn,
Цахим хуудас: www.tojha.gov.mn

2022.10.18 № 1/5253

тантай 2022.10.11 -ны № 02/2614 -Т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Захиргааны хэм хэмжээний актын
улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийсэн
тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Тэтгэврийг хөнгөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2022 оны А/185, А/186 дугаар тушаалыг тус тус үндэслэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 3018 дугаарт бүртгэлтэй Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Тэтгэврийг хөнгөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д орсон нэмэлт, өөрчлөлтийг хүлээн авч холбогдох хөдөлгөөн хийснийг үүгээр мэдэгдье.



Х.НЯМБААТАР

А4 Файл.2022

151504358



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар

A/185

ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний тайланг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-ын хөдөлмөрийн хортой нөхцөл гэсэн 2 дугаар бүлэгт дараах нэмэлтийг оруулсугай.

1.1. 19 дэх хэсэгт "Химийн лабораторийн судалгааны ажилтан".

1.2. 25 дахь хэсэгт "Дулаан сантехникийн албаны гагнуурчин".

1.3. 27 дахь хэсэгт "Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн цахилгаанчин", "Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн сэрээт ачигчийн оператор", "Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн мастер".

2. Дараах агуулга бүхий 30, 31 дэх хэсгийг хөдөлмөрийн хортой нөхцөл гэсэн 2 дугаар бүлэгт шинээр нэмсүгэй.

2.1. "30 Төмөр замын "Цемент савлагч" /бетон дэрний үйлдвэрийн/, "Вагон засварын газрын үйлчлэгч" /Зүүнхараа дахь ачаа вагон засварын депогийн/, "Вагон цэвэрлэгч, угаагч" /Зүүнхараа дахь ачаа вагон засварын депогийн /, "Цахилгаан ба хийн гагнуурчин" /Зүүнхараа дахь ачаа вагон засварын депогийн/, "Хөдлөх бүрэлдэхүүний засварын слесарь, засварчин".

2.2. 31. "Шахмал түлш үйлдвэрлэлийн салбарын бутлуурын машинч, барьцалдуулагчийн машинч, холигчийн машинч, хэвлэгчийн машинч, хатаагчийн машинч, хатаах зуухны машинч, үндсэн тэжээлийн машинч, автомат савлагчийн машинч, нам даралтын зуухны машинч, засварын бригадын тоноглолын засварчин, цахилгаанчин, гагнуурчин".

3. "Хөдөлмөрийн хүнд нөхцөл" гэсэн 4 дүгээр бүлгийн 3 дахь хэсгийн "Хөдлөх бүрэлдэхүүний засварын слесарь, засварчин" гэснийг хассугай.

4. Энэхүү тушаалыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, холбогдох хуулийн заалтад дурдсан болзлыг хангаж байгаа тохиолдолд тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоохыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/-д зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ



Д АМАРБАЯСГАЛАН
151221850



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/186

Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын
доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд
нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад
нэмэлт оруулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг
үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар
баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн
хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-ын
хөдөлмөрийн хортой нөхцөл гэсэн 2 дугаар бүлэгт дараах агуулга бүхий 29 дэх хэсэг
нэмсүгэй

"29 Бохир усны төвлөрсөн цэвэрлэх байгууламжийн ээлжийн инженер, бохир
ус сорох машины жолооч, лаг усгүйжүүлэх байгууламж, лаг талбайн техникч,
фильтр прессийн оператор, центрфугийн машинч, цахилгааны техникч, хяналтын
техникч, ээлжийн техникч, хром сульфидын машинч, тоног төхөөрөмжийн техникч,
төвлөрсөн системийн насос станцын машинч, ээлжийн машинч, агааржуулах станц,
идэвхит лаг, түүхий үлдэцийн насос станцын машинч, сараалж, элс, тос баригч,
тунгаагчийн машинч (операторч), лаг, талбайн оператор, халдваргүйжүүлэх
станцын оператор, хлорын засварчин (слесарь), бохир усны шугам хоолойн
техникч, засварчин (слесарь), тоног төхөөрөмжийн инженер, засварчин (слесарь),
цэвэрлэх байгууламжийн цахилгаан ба хийн гагнуурчин, хими бактериологийн
лабораторын бактериологич, химич, лаборант, дээж авагч, шил сав угаагч".

2. Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/193, А/77 дугаар тушаалын
Нэг дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тушаалыг мөрдөж, холбогдох хуулийн заалтад дурдсан болзлыг
хангаж байгаа тохиолдолд тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоохыг Нийгмийн
даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/-д
зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ



Д.АМАРБАЯСГАЛАН

151221858



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 08 сарын 01 өдөр

Дүгээр 04

Шинэчлэлт

Оршуулгын тэтгэмжийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөг /2 000 000/-өөр шинэчлэн тогтоосугай.

2. Амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөг /3 500 000/-өөр тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 16 дугаар тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



А.АРИУНЗАЯА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар АН/91

Улаанбаатар хот

Даатгуулагчийн төрлийн код шинээр
батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6, 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.2, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3.2.4 дэх хэсэг, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Маягт батлах, тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 49/А/39 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр, улсын төсвөөс цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр болон 16 насанд хүрсэн одой хүн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэйн улмаас нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон боловч хөдөлмөр эрхэлж байгаа иргэнд ажил олгогчоос олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "70" гэж тогтоон, ажил олгогчийн төлбөл зохих тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ (10.3-12.3), даатгуулагчийн төлбөл зохих тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ (9.3), нийт хувь хэмжээ (19.6-21.6)-гээр төлүүлэхээр, төрийн тусгай албанд цэрэг /цагдаа/-ийн цолтойгоор алба хааж байгаа ажилтны тухайн байгууллагын захиалгаар төрийн зардлаар суралцсан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг "71" гэж тогтоон, тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ (2.0)-гээр төлүүлэхээр тус тус баталсугай.


515110783

Хоёр. Даатгуулагчийн төрлийн батлагдсан кодыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нар, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), ажил олгогчийн шимтгэл төлөлтийн програм хангамжид өөрчлөлт оруулж 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг, дүүргийн хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалаар баталсан даатгуулагчийн төрлийн "70", "71" кодыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Дөрөв. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Б.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  А.АРИУНБОЛД



АЖИЛ ОЛГОГЧИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ, КОД

Д/А	Даатгуулагчийн төрөл		Шимтгэл тооцох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /ХХТАО/	Шимтгэл төлөх хэмжээ /хувиар/						Нийт	Хууль, тогтоол журмын үндэслэл	
	Даатгуулагчийн төрлийн код	Даатгуулагчийн нэр		Тэтгэвэр	Тэтгэмж	ЭМД	Ажилгүйдэл	ҮОМШӨ				
			ажил олгогч	ажил олгогч	ажил олгогч	ажил олгогч	ажил олгогч	ажил олгогч	ажил олгогч			
1	01	Аж ахуйн нэгж, байгууллагын энгийн ажилтан	8.5	8.5	1.0	0.8	2.0	2.0	0.2	0.8-2.8	24.0-26.0	НДТХ-4.2.1 4.2.2 15.1
2	40	Үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа ажилтан /Даатгуулагч/	8.5	8.5	1.0	0.8	2.0	2.0		0.8-2.8	23.6-25.6	НДТХ-4.6, 15.1
3	22	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан /энгийн/	8.5	8.5	1.0	0.8				0.8-2.8	19.6-21.6	НДТХ-4.6, 15.1
4	20	Ажил олгогчийн захиалгаар суралцагч	8.5		1.0						9.5	НДСОТТХ -3.3 НДТХ-15.1 3Г-ын 1994 оны 212-р тогтоолын хавсралт-2
5	06	Хүүхэд асрах чөлөөтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан эх	8.5		1.0						9.5	
6	17	Жирэмсний, амаржсаны амралттай байгаа ажилтан эх	8.5		1.0		2.0	0.2		0.8-2.8	12.5-14.5	
7	21	Нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтан	8.5		1.0		2.0	0.2		0.8-2.8	12.5-14.5	НДСОТТХ-ийн 3.3 ҮНДЕГ-ын дэргэн 2009 оны 206-т тушаалаар баталсан аргачлал
8	23	Эрх бүхий байгууллагаас сертификат аваагүй БНСУ-ын иргэн	8.5	8.5	1.0	0.8	2.0	2.0	0.2	0.8-2.8	24.0-26.0	НДТХ-4.2.1 4.2.2 15.1
9	24	Эрх бүхий байгууллагаас сертификат авсан БНСУ-ын иргэн			1.0	0.8	2.0	2.0	0.2	0.8-2.8	7.0-9.0	НДТХ-4.2.1 4.2.2 15.1 3Г-ын гэрээ
10	25	Жилд 7 сараас доошгүй хугацаанд үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг улирлын чанартай үйл ажиллагаатай байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч /ажил зогссон үед/	8.5		1.0		2.0	0.2		0.8-2.8	12.5-14.5	ХТХ-46.3 НДТХ-15.1, 16.7, 16.8
11	14	Сул зогсолтын үеийн олговор авч байгаа даатгуулагч	8.5	8.5	1.0	0.8	2.0	2.0	0.2	0.8-2.8	24.0-26.0	ХТХ-56, НДТХ-4.2.1 4.2.2 15.1
12	50	Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээтэй өмгөөлөгч	8.5	8.5	1.0	0.8	2.0	2.0	0.2	0.8-2.8	24.0-26.0	ХЗЗБТХ-39.1, НДТХ-4.2.1, 15.1
13	28	Улсын хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн ажилгүй байгаа эхнэр/ нөхөр	8.5				2.0				10.5	НДТХ-15.1 ГТХ-282.7

14	29	Улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа эхнэр/ нөхөр	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	8.5	1.0	2.0	0.2	0.8-2.8	12.5-14.5	НДТХ-15.1 ХТХ-36.4
15	30	Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчийн тодорхой ажил эрхлээгүй эхнэр/ нөхөр	Төрийн албан хаагчийн үндсэн цалингийн дундаж	8.5	1.0	2.0	0.2	0.8-2.8	12.5-14.5	НДТХ-15.1 ДАТХ-23.2
16	31	Иргэний хамгаалалтын болон дайчилгаанд хамрагдсан даатгуулагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	8.5	1.0				9.5	НДСОТТХ-3.3 НДТХ-15.1 ЗГ-ын 1994 оны 212-р тогтоолын хавсралт-2
17	32	Хууль бусаар ажлаас зайлуулагдсан, мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн ажилтан	ХХТАО	8.5	1.0				9.5	
18	34	Сул зогсолтын үеийн олговор авч байгаа тэтгэвэр тогтоолгосон ажилтан	Сул зогсолтын үеийн олговрын хэмжээ нь тухайн ажилтны үндсэн цалингийн 60%-аас багагүй байх ба хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна	8.5	1.0	0.8		0.8-2.8	19.6-21.6	ХТХ-56, НДТХ-4.6, 15.1
19	37	Лам санваартан	ХХТАО /энэхүү орлогын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна/	8.5	1.0	0.8	2.0		24.8	ТСХХТХ-7.8, НДТХ-4.2.1, 15.1, ЭМДТХ-8.1.1
20	38	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	8.5	1.0			0.8-2.8	19.6-21.6	НДТХ-4.6, 15.1, НДСОТТХ-3.3
21	39	Тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа 1 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтан	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	8.5	1.0			0.8-2.8	19.6-21.6	НДТХ-4.6, 15.1, НДСОТТХ-3.3
22	43	Цаа буга маллан амьдарч буй цаатан иргэн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	11.5	1.0				12.5	НДТХ-4.7, 15.2, 16.9, 16, 10, ЗГ-ын 1994 оны 212, 2015 оны 318, 2018 оны 221-р тогтоол
23	11	Цэрэг, цагдаагийн ажилтан	ХХТАО			2.0	2.0		4.0	ЭМДТХ 8.1.1
24	08	Хугацаат цэргийн албан хаагч, Цэрэг, хууль сахиулахын сургуулийн сонсогч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	8.5	1.0				9.5	НДСОТТХ-3.3, НДТХ-15.1, ЗГ-ын 212-р тогтоолын хавсралт-2
25	53	Цэргийн гэрээт алба хаагч	ХХТАО			2.0	2.0		4.0	НДТХ-15.1, ЗГ-ын 2008 оны 194-р тогтоол
26	41	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа цэргийн алба хаагч эх	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ			2.0			2.0	ЦАХТТТХ-24, ЭМДТХ-8.1.1, 8.1.2
27	42	Нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан цэргийн алба хаагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ			2.0			2.0	ЦАХТТТХ-24, ЭМДТХ-8.1.1, 8.1.2
28	51	Шилинж ажилласан цагдаагийн алба хаагчийн ажилгүй байгаа эхнэр/нөхөр	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	8.5	1.0	2.0	0.2	0.8	13.5	ЦАТХ /Шинэчилсэн найруулга/- 87.3

29	9	Сайн дурын даатгуулагч	ХХТАО		11.5		1.0				13.5	НДТХ-4.3, 15.2
30	26	Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж байгаа Монгол Улсын иргэн	ХХТАО		11.5						11.5	НДТХ-4.2.4, 15.8, НДҮЗ-н 2018 оны 5-р тогтоол, НДЕГ-ын даргын 2014 оны А/110
31	52	БНСУ-д ажиллаж байгаа Монгол Улсын иргэн /Сайн дурын даатгуулагч/	ХХТАО /40 000 ВОННООС БАГАГУЙ/		11.5		1.0				13.5	НДТХ-4.3, 15.2, НДҮЗ 2018-5 тогтоол, НДЕГ-ын 2021-А/35 тушаал
32	61	Цэргийн цолны мөнгө авсан хүүхдээ асарч байгаа цэргийн алба хаагч эх	Олгосон цэргийн цолны мөнгөний хэмжээ					2.0	2.0		4.0	НДТХ-32.1, ЭМДТХ-8.1.1, ЦАХТТХ-7.1, ЦАХЭЗБТХ-5.1.2
33	62	Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		10.0						10.0	АЖТДШНТХ-1
34	63	Тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч	420000 төг		10.0						10.0	МХХЭТДШНТХ-4.1, 5.1
35	64	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дурын даатгуулагч эх /тэтгэмжийн даатгалын сангаас 50 хувийг төлнө/	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		5.75		0.5				6.25	НДТХ-4.3, 15.2, НДСОТТХ-3.6.2
36	65	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дурын даатгуулагч эх /улсын төсвөөс 50 хувийг төлнө/	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		5.75		0.5				6.25	НДТХ-4.3, 15.2, НДСОТТХ-3.6.3
37	66	ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тахир дутуугийн тэтгэвэр авагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		8.5						8.5	НДТХ-15.1, НДСОҮОМШӨТТТХ-4.5
38	67	Цэргийн алба хаасан хугацааг иргэний байгууллагад ажилласнаар тооцон улсын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлээ төлүүлсэн иргэн	ХХТАО, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ				1.0				9.5	НДТХ-15.1, ЦАХТТХ-6.3
39	68	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого авсан хүүхдээ асарч байгаа эх	ХХТАО		8.5	1.0	0.8	2.0	2.0	0.2	24.0-26.0	НДСОТТХ-3.3, НДТХ-15.1, 5, ЭЗОХӨТЭЭТОТХ-6.2
40	69	Цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосны дараа цэргийн цолтой ажиллаж байгаа алба хаагч	ХХТАО		-	-	-	-	-	-	-	НДТХ-4.6, ЭМДТХ-6.1.6, 8.2.3, ЦАХТТХ-8, 10
41	70	Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан /энгийн/	ХХТАО		8.5	1.0	0.8			0.8-2.8	19.6-21.6	НДТХ-4.6, 15.1, ХТХ-144, НДСОТТХ-7, ЦАХТТХ-10, НХТХ-12
42	71	Цэрэг, цагдаагийн байгууллагын захиалгаар суралцагч цэргийн цолтой алба хаагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		-	-	-	2.0	-	-	2.0	ЦАХЭЗБТХ-4.3.2, ЭМДТХ-6.1.1